



БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ
СУМЫН ЗАСАГДАРГЫН
ОРЛОГЧ **ОЮУБ.ДАВААСҮРЭН**
2024 оны 2 дугаар сарын 16-ны өдөр

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын цэцэрлэгт хүүхдийн
хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авах

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ДУГАГУСЗДТГ/2024001

2024 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тендерийн цар хүрээ: Өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, Үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу гэгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах Үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын Үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.

Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа Үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.

Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг:

Тендер шалгаруулалтын нийт болон багц тус үрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж:

Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, Үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө

Худалдан авах ажиллагааны цахим систем:

Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)

/цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:

Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөлт с урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон Үйлдэл, эс Үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

Сонирхогч этгээд, оролцогч:

Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн ирүүлнэ

Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нхцл Үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна. Монгол Улсын олон улсын гэрээнд Үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан Үйлчилгээний хураамж төлсөн байна. ШЗ-ны 6.4-т заасан Үйлчилгээний хураамжийг аливаа Үндэслэлээр буцаан олгохгүй.

Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ:

Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй

Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

ШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Нийлүүлэх барааны гарал үүсэл:

ШЗ-ны 1.3-т өөр өөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно

Б.АГУУЛГА

Тендер шалгаруулалтын баримт бичиг:

Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн Үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл. захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална. Сонирхогч этгээд ТШЗ, гогдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өрчлөлт оруулсан бол өрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах:

Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

ШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт:

Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна. ШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл:

Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендер оролцогч бэлтгэн ирүүлнэ. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын, олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан

хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөр орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

Тендерийн иж бүрдэл:

Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

ШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/; захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал; оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг; санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг, бараа нийлүүлэлтийн хуваарь тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг; ШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны Үнийн задаргаа;

ШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

Тендерийн жишиг маягтууд:

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.

Хувилбарт санал:

Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:

Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ: Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг; тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг:

Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтой заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;

Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

ШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Чадавхын болон туршлагын шаардлага:

Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт:

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт :

Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана. ШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

ШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөөл үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

Тендерийн валют:

Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

Тендер хүчинтэй байх хугацаа:

Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш рийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана

Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуу буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

Тендерийн баталгаа:

Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ

Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

Тендер баталгаажуулах, илгээх:

Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

ШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

Тендер хүлээн авах эцсийн хугацаа:

Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

Тендерийн талаар тодруулга авах:

Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх:

Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

Тендерийг Үнэлэх:

Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

Арифметик алдааг залруулах:

Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна. ШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

Давуу эрх олгох:

Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

ШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт:

Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох:

Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

ШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.

ШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

Тендерийг эрэмбэлэх:

Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

Оролцогчийн чадавхыг дахин магадлах:

Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.

ШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

ШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Шийдвэр хүргүүлэх:

Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

Гүйцэтгэлийн баталгаа:

Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн т свийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах:

Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээнийн хц лийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж оролцогчид хүргүүлнэ.

Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Дундговь аймгийн Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>ДУГАГУСЗДТГ/2024001</i>

ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн Багц № 2: Сүү, сүүн бүтээгдэхүүн Багц № 3: Гурил гурилан бүтээгдэхүүн Багц № 4: Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо Багц № 5: Бусад
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ҮеҮү”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг : 32,895,000 Багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн –13,110,000 Багц № 2: Сүү, сүүн бүтээгдэхүүн – 5,270,000 Багц № 3: Гурил гурилан бүтээгдэхүүн – 3,049,500 Багц № 4: Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо – 8,066,000 Багц № 5: Бусад – 3,399,500
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэг Хаяг: Дэлгэр хонгор 4 -р баг Утасны дугаар: 91024421, 88215055 ,88858805 Цахим шуудангийн хаяг: www.tender.gov.mn
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн ө м н ө х уулзалт зохион байгуулах эсэх: “ҮеҮү”

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл , арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “зөвшөөрөхгүй “
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “ҮеҮй”
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах Үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”</p> <p>Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын Үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх. (Бараа нийлүүлэх гэрээ, захиалагч байгууллагын тодорхойлолт.)</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 18.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 50 хувиас багагүй байх.</p> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: [Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо барааны онцлог, тоо хэмжээг харгалзан зайлшгүй шаардлагыг тусгана. Тухайлбал дараах шаардлагууд байж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</p> <p>Ижил төстэй гэрээний туршлага: 2021-2023 он /ижил төстэй ажлын гэрээний мэдээллийг маягт 3, 4, 5 жагсаалтаар ирүүлэх ба захиалагчийн тодорхойлолттой хамт заавал ирүүлэх/</p> <p>Нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлт: Бараа бүтээгдэхүүн хүргэх тээврийн хэрэгсэл заавал байна</p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл /зөвшөөрөл : “Шаардана” НӨАТ төлөгчийн гэрчилгээ
ТШЗ 19.1	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”

	Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2023
ТШЗ 20.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Шаардахгүй”
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон Үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” Incoterms Дундговь аймгийн Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг
ТШЗ 24.1	<i>Тендерийн баталгаа: “Үгүй”</i>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ ирүүлэх шаардлагагүй /цахимаар/ 2. Татварын газрын тодорхойлолт /цахимаар/ 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /цахимаар/ 4. Харилцагч банкны тодорхойлолт / өр, зээлгүй/ 5. Үнийн санал /батлагдсан жагсаалтаар гаргаж ирүүлэх/ 6. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл , маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. 8. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, гэрээний дагуу чанарын баталгаатай бараа бүтээгдэхүүнийг захиалгын дагуу хүргэж, хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ. 9. Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. 10. Захиалагчийн тодорхойлолт заавал ирүүлэх /тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх/ ирүүлээгүй бол татгалзах Үндэслэл болно. Жич: Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /PDF/ хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: : 2024 оны 03дугаар сарын 14 Цаг: 11 цаг 00 минут
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх ба нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.

	<p>Огноо: 2024 оны 03дугаар сарын 14 ний Цаг:</p> <p>11 цаг 30 минут</p> <p>Тендер нээх газрын хаяг: Дундговь аймгийн Говь - Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэг</p>
<p>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</p>	
ТШЗ 29.2.	<p>Тендер Үнэлэх Үндсэн шалгуурыг харьцуулах Үнээс өөр өөр тогтоох эсэх:</p> <p>“Үгүй”</p>
ТШЗ 31.1.	<p>Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:</p> <p>“Баримт бичгийг жагсааж бичих”</p>
ТШЗ 32.1	<p><i>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх:</i></p> <p>“Ашиглахгүй”</p>

Цэцэрлэгийн 2024 онд нийлүүлэгдэх хүнсний бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт

Говь-Угтаал сум

Д/д	Багцын нэр	Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Баглаа боодол	Тоо ширхэг	Тайлбар	
1	Мах, махан бүтээгдэхүүн	1	хонь мах	кг		740	Гарал үүслийн бичигтэй байх	
		2	Ямаа мах	кг		610	Гарал үүслийн бичигтэй байх	
		3	Дайвар бүтээгдэхүүн	ш		90	Гэдэс цувдай	
		Дүн:- 13,110,000						
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	1	Үхрийн сүү	л		500	Эрүүл малаас гаралтай, амт, тослог хэвийн байх, ус гурил гэх мэт хольцгүй гарал үүслийн бичигтэй байх	
		2	Тараг	л		400		
		3	Аарц	кг		200		
		4	Эзэгий	кг		18		
		Дүн- 5,270.000						
3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	1	1-р гурил - УБ	кг	50 аар савлагдсан байх	465	Савлагаа бүрэн, ус чийг нэвтрээгүй байх, амт үнэргүй, уусдаггүй байх	
		2						2 дугаар гурил
		3					Савлагаа бүрэн, хадгалах хугацаа дуусаагүй байх	
		4	савхан	ш			40	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй
		5	Зочин	ш			36	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй
		6	Жимст	ш			36	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй
		7	Та чи хивэг	ш			76	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй
		8	Та чи онцгой	ш			76	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй

		9	Та чи нахиа	ш		71	Савалгаа бүтэн хадгалах хугацаа дуусаагүй
		Дүн- 3,049,500					
4	Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо	1	Саримсны гол	кг		2	Шинэ ургацын хөгцөрө ө гүй байх
		2	Нэрс	ш		30	Хугацаа дуусаагүй, шинэ байх
		3	Алим	кг		60	Шинэ ургацын зөөлрөөг ү й байх
		4	Аньс	кг		30	Шинэ ургацын байх
		5	Үзэм	кг		36	Хог, чулуугүй цэвэрхэн байх

		6	Чацаргана	кг		90	Шинэ ургацын чанар сайтай байх
		7	Төмс	кг		820	Шинэ ургацын байх
		8	Лууван	кг		200	
		9	чинжүү	Ъг		80	
		10	Байцаа	кг		304	
		11	Сонгино	кг		50	Шинэ ургацын байх
		12	Брокли	кг		62	
		13	Хүрэн манжин	кг		36	
		14.	Кг огурцы	кг		90	Шинэ ургацын байх
		15	Помдиор	кг		90	Шинэ ургацын байх
		Дүн- 8,086,000					
5	Бусад хүнс	1	Хөц будаа	кг	1кг савлагд сан	20	MNS 4515-1997 стандарт хангасан байх
		2	Гурвалжин будаа	кг	1кг савлагд сан	30	MNS 6511- 2015стандарт хангасан байх
		3	Шар будаа	кг	1кг савлагд сан	60	MNS 0533-1998 стандарт хангасан байх
		4	Цагаан будаа	кг	25 кг савлагд сан байх	120	MNS ISO 7031:2000 стандарт хангасан байх
		5	Овьёос	уут	05 кг аар савлагд сан байх	60	Савлагаа задраагүй чанарын баталгаатай хугацаа дуусаагүй байх
		6	Далайн байцай	уут	Уутанд аа 10 ширхэгт эй байх	15	Савлагаа задраагүй чанарын баталгаатай хугацаа дуусаагүй Байх
		7	Каш	кг	1кг савлагд сан	60	MNS 0243-2003 стандарт хангасан байх
		8	Шпагети	ш		30	Шөлний зориулалттай бүхий уусаж нялцайдаггүй
		9	Лапша гоймон	кг	3кг савлагд сан байх	50	Шөлний зориулалттай бүхий уусаж нялцайдаггүй
		10	Кг-ийн гоймон	кг	2кг савлагд сан	20	Уусаж нялцайдаггүй (Цесүйлдвэрийн гоймон)

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

БАГЦ-1

д/д	Нэр	х/н	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ	ТӨШХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотерийн нөхцөлийн дагуу тогтоосон барааг нийлүүлэх хугацаа		
							Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Үхэрийн сүү	л	4000	500	2000000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
2	Эзэгий	кг	15000	18	270000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
3	Тараг	л	4500	400	1800000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
4	Аарц	л	6000	200	1200000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
	Нийт дүн				5270000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
1	Дайвар бүтээгдэхүүн	ш	1000	90	90000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
2	Хонины мах	кг	11000	740	8140000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
3	Ямааны мах	кг	8000	610	4880000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
	Дүн				13110000				

Багц-.2 Дотоод									
1	1-р гурил	кг	2320	465	1078800	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
2	2-р гурил	кг	1800	90	162000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
3	Савхан	ш	6600	40	264000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
4	Зочин	ш	6300	36	226800	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
5	Жимст	ш	3200	36	115200	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
6	Та чи хивэг	ш	4500	76	342000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
7	Та чи онцгой	ш	6000	76	456000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
8	Та чи нахиа	ш	5700	71	404700	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
	Дүн				3049500				
10	Сармисны гол	кг	11000	2	22000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
11	Нэрс	ш	8500	30	255000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
12	Алим	кг	7500	60	450000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
13	Аньс	ш	8500	30	255000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
14	Үзэм	кг	12000	36	432000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
15	Чацаргана	ш	8500	90	765000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	

16	Төмс	кг	1800	820	1476000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
17	Лууван	кг	2000	200	400000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
18	Чинжүү	кг	8500	80	680000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
19	Байцаа	кг	2000	304	608000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
20	Сонгино	кг	3000	50	150000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
21	Брокли	кг	10000	62	620000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
22	Хүрэн манжин	кг	3000	36	108000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
23	Огурцы	кг	11000	90	990000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
24	Помдиор	кг	9500	90	855000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
	Дүн				8066000				

Багц :3 Импортын буюу бусад

1	Гурвалжин будаа	ш	10500	30	315000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
2	Хүүхдийн будаа	ш	5000	60	300000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
3	Цагаан будаа	кг	3900	120	468000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
4	Хөц будаа	ш	5500	20	110000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
5	Шар будаа	кг	5200	60	312000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
6	Кг гоймон	кг	4200	20	84000	Ду: Говь-Угтаал сумын			

						хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
7	Туузан гоймон		2200	50	110000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
8	Шпегати гоймон	ш	3200	30	96000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
9	Масло	ш	3300	25	82500	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
10	Далайн байцаа	ш	4800	15	72000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
11	Овьёос	ш	3000	60	180000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
12	Ургамлын тос	ш	12000	38	456000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
13	Эсгэгч	ш	200	45	9000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
14	Сахар	кг	4800	120	576000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
15	Давс	ш	2000	28	56000	Ду: Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг	2024-02-01	2024-12-31	
16	Их монгол цай	ш	5500	10	55000	20кг хайрцагтай	2024-02-01	2024-12-31	
17	Ногоон сонгино	ш	3300	36	118000	Ууттай 500 гр	2024-02-01	2024-12-31	
	Дүн				3399500				
	Нийт дүн				32895000				

Эрхлэгч..... / П.Отгонжаргал /

Нягтлан бодогч/ Д.Дулам /

Нярав/ Э.Болормаа /

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Захиалагч болон Үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын Үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

/Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана./

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны Үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			

3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг б ө г л ө н ө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	[Барааны нэрийг бичих]	[нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2024.02.01-ээс 2024.02.14] гэх мэт	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2						
3						
...						

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [Үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] өртөгөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө өр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт Үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**30 ба түүнээс дээш хоногийн тоо**] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад Үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ ҮҮ.

Маягт 2 **Барааны Үнийн задаргаа**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал Үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж Үнэ	Нэр төрөл бүрийн бүгд Үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад Үйлчилгээний Үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт Үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Тийм/Үгүй
2										
...										
Тендерийн нийт Үнэ										

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын Үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал Үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал Үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "тийм" гэж бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр б ө г л ө н ө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дҮн
7.	Гэрээ гҮйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

ҮГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.....хот/айм
аг Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), н г
талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь
Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн Зөвшөөрч энэхүү гэрээг дараах
нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх,
дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон Үнэ төлөхтэй
холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны Үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан Үнийн дүнг тоогоор болон Үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний Үнэ” гэх) байна. Гэрээний Үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний Үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүдт төлөөлнө Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын Үсэг]_____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын Үсэг]_____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: **2024 оны 03 дугаар сарын 04-ний** өдөр

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**

Тендер шалгаруулалтын нэр: **Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДУГАГУСЗДТГ/2024001**

Нийт төсөвт өртөг: **32,895,000**

Тендер шалгаруулалтын арга: **“Харьцуулалт”**

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэг нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

Багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн Багц № 2: Сүү, сүүн бүтээгдэхүүн

Багц № 3: Гурил гурилан бүтээгдэхүүн

Багц № 4: Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо Багц № 5: Бусад

1. Тендерийг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 12 цаг 30 минут–аас өмнө тендерийн баримт бичигт Заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 12 цаг 30 минутад зохион байгуулна.
2. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
3. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
4. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
5. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Үгүй”**
6. Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй Үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн Үнийг төлснө өр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.
7. Тендер шалгаруулалтыг урьдчилан Зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
8. Тендер шалгаруулалтыг хоёр Үе шаттай Зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Оролцогч цахим системийн Үйлчилгээний хураамж төлснө өр тендер илгэ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын засаг даргын тамгийн газрын 2 давхарт

Утас 91024421, 88215055 ,88858805

